



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/142

Мандалговь

Бог мал угаах ванн шинээр барих
ажил хүлээлцэх ажлын комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Бог мал угаах ванн шинээр барих ажил”-ын багц-3 (Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал) ажлын хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ш.Мөнхдүүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Ганчимэг (Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн аймгийн ажилтан)

Гишүүд: Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Т.Цэвэлмаа (Баянжаргалан сумын Засаг дарга)

Д.Буджав (Цагаандэлгэр сумын Засаг дарга)

Ө.Мөнх-Амгалан (Говь-Угтаал сумын Засаг дарга)

Ю.Отгондэлгэр (“Тааны амт” ХХК-ийн захирал)

Хоёр. Бог мал угаах ванн шинээр барих ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Ш.Мөнхдүүрэн)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060611